



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 08 өдөр

Дүгээр А/498


Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, ИНД-65 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх зэрэглэл"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэгийн удирдагчийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдийн ур чадвар хадгалах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг 2018 оны 8 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Е.Эрдэнэбат/-т даалгасугай.
3. Нислэгийн удирдагчийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдийн ур чадвар хадгалсан цагийн нэмэгдлийг батлагдсан журмын дагуу тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /М.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.
4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны А/81 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

ХАМАНГАЛТАЙ ХУДАГ  
2018-08-28

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2018 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн  
А/115 дугаар тушаалын хавсралт

## НИСЛЭГИЙН УДИРДАГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ, ЗЭРЭГЛЭЛ ЭЗЭМШИГЧДИЙН УР ЧАДВАР ХАДГАЛАХ ЖУРАМ

### Нэг. Зорилго

1.1. Нислэгийн удирдагчийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчид үйлдвэрлэлийн ээлжийн зохион байгуулалтад нислэгийн удирдагч мэргэжлээр идэвхтэй ажиллаж байгаа эсхүл нислэгийн удирдагчийн ажлын байранд орон тоотой боловч ажлын шаардлагаар Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний харьяа байгууллага, ажлын хэсгүүдэд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар томилогдон ажиллах тохиолдолд нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлага, туршлагыг тогтмол хадгалах, дээшлүүлэх болон хүний нөөцийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан ур чадвараа хадгалахад энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. ИНД-65, ИНД-67-ийн шаардлагуудыг хангасан нислэгийн удирдагчийн хүчин төгөлдөр үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдэд (цаашид "Ур чадвар хадгалагч" гэх) энэ журам хамаарна.

2.2. Ур чадвар хадгалагч нь 3.1-т тавигдсан шаардлагуудыг бүхэлд нь хангасан байх бөгөөд дээрх заалтуудын аль нэгийг хангахгүй байх тохиолдолд энэхүү журам хамаарахгүй.

2.3. Ур чадвар хадгалагч нь ИНД-65-ийн дагуу олгогдсон зэрэглэлүүдийн хүрээнд ИНД-65.309 "Дадлага туршлагад тавигдах шаардлага" заалтад үндэслэн ур чадвар хадгалах үйл ажиллагааг дараах ажлын байруудад гүйцэтгэнэ. Үүнд:

- Аэродромын нислэгийн удирдлагын;
- Ойртолтын нислэгийн удирдлагын;
- Ойртолтын ажиглалтын удирдлагын;
- Бүсийн нислэгийн удирдлагын;
- Бүсийн ажиглалтын удирдлагын;
- Дадлагажуурын байр.

### Гурав. Ур чадвар хадгалагчид тавигдах шаардлага

- 3.1. Ур чадвар хадгалагч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- а. ИНД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл /Air traffic services personal licenses and ratings/, ИНД-67 "Иргэний нисэхийн эрүүл мэндийн стандарт, гэрчилгээ" /Medical standards and certification/ дүрмүүдээр тавигддаг нислэгийн удирдагчийн мэргэжлийн болон эрүүл мэндийн шаардлагыг хангасан хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигч байна.
  - б. Мэргэжлийн англи хэлний 4 ба түүнээс дээш түвшний шаардлага хангасан байна.
  - в. Тухайн ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлын байранд тавигдах шаардлагуудыг хангасан байна.

ХАМГААГАХ ХУСЪ  
2018-08-28  
АЛМЭХ



## Дөрөв. Ур чадвар хадгалах үйл ажиллагаа, хяналт

4.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигацийн бодлого хариуцсан нэгж нь энэхүү журмын 3.1 дэх шаардлагуудыг хангасан ур чадвараа хадгалах шаардлагатай нислэгийн удирдагчийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдийн жагсаалтыг ур чадвар хадгалах ажлын байр тус бүрээр гарган батална.

4.2. Энэ журмын 4.1-т заасан жагсаалтыг ажлын байрны хэрэгцээ шаардлагатай уялдуулан жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр гарган батална.

4.3. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага нь энэхүү журмын 4.1 дэх заалтын дагуу батлагдсан жагсаалтыг үндэслэн сар бүрийн хуваарийг ур чадвар хадгалах ажлын байр тус бүрээр гарган Агаарын навигацийн бодлого хариуцсан нэгжийн удирдлагаар батлуулна.

4.4. Ур чадвар хадгалагч нь ажлын бус цагаар ажиллана.

4.5. Ур чадвар хадгалагч нь зөвхөн ИНД-65.307 (а) заалтын дагуу тогтоогдсон зэрэглэлийн дагуу ажиллана. Үүнд:

1/ Аэродромын нислэгийн удирдлагын зэрэглэл нь үйлчилгээ явагдах аэродромд НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, түүнд хяналт тавих;

2/ Ойртолтын нислэгийн удирдлагын зэрэглэл нь үйлчилгээ явагдах аэродром(ууд)-ын ойртолтын НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;

3/ Бүсийн нислэгийн удирдлагын зэрэглэл нь тогтоогдсон хяналттай агаарын зай буюу агаарын замын дагуу НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;

4/ Ойртолтын ажиглалтын удирдлагын зэрэглэл нь ойртолтын НХУ-ын үйлчилгээ үзүүлэх нэгжийн хариуцлагын дор тухайн аэродром(ууд)-ын хариуцлагын бүсэд бодит ажиглалтын систем ашиглан НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;

5/ Ойртолтын нарийвчлалтай радар-удирдлагын зэрэглэл нь тухайн аэродромын хөдөлгөөнд нарийвчлалтай ойртолтын радар-удирдлагын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;

6/ Бүсийн ажиглалтын удирдлагын зэрэглэл нь тогтоогдсон хяналттай агаарын зай буюу агаарын замын дагуу бодит ажиглалтын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих.

4.6. Ур чадвар хадгалагч нь олгогдсон зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгэж эхлэхийн өмнө холбогдох бүх бодит мэдээлэлтэй танилцсан байна.

4.7. Ур чадвар хадгалагч нь 2.3-т заагдсан ажлын байруудад ур чадвар хадгалахдаа тухайн ажлын байранд мөрдөгддөг бүх дүрэм, журмууд, бусад холбогдох заавруудыг чанд мөрдөн ажиллана.

4.8. Ур чадвар хадгалагч нь батлагдсан хуваарийн дагуу ур чадвараа хадгалах бөгөөд ур чадвар хадгалсан цагийг хурууны хээгээр бүртгүүлнэ.

4.9. Ур чадвар хадгалах үйл ажиллагаа нь батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулагдах бөгөөд ур чадвар хадгалагч нарын ажлын гүйцэтгэлийг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага гаргана.

ХЯНАЛТТАЙ ХУСЬ

2018-08-28

ААНХ

4.10. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын дарга нь ур чадвар хадгалах үйл ажиллагааны чанар, үр дүнд хяналт тавих үүрэг хүлээнэ.

4.11. Ур чадвар хадгалагч нь ИНД-65.309.(б) "Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь олгосон зэрэглэлийн дагуу тухайн ажлын байранд сард 10-аас доошгүй цаг ажилласан, эсхүл дадлагажуурт дадлага хийж ур чадвараа хадгалах ба сүүлийн 21 хоногт олгогдсон зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгээгүй бол бие дааж ажиллах чадвараа дахин шалгуулна"-ыг үндэслэн тухайн ажлын байранд ур чадвараа сард 20 хүртэл цаг хадгална.

4.12. Ур чадвар хадгалагч нь мэргэжлийн мэдлэг, дадлага туршлага, ур чадвараа хадгалахын тулд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд шинээр нэвтэрч буй техник, технологийн сургалтад тухайн ажлын байрны ажилтнуудын нэгэн адил хамрагдана.

#### Тав. Ур чадварын нэмэгдэл цалин тооцох

5.1. Ур чадвар хадгалагчид ур чадварын нэмэгдэл цалинг энэхүү журмын 4.9 дэх заалтын дагуу гаргасан гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

5.2. Ур чадварын нэмэгдэл цалинг батлагдсан хуваарь, цагийн бүртгэл, гүйцэтгэлийг үндэслэн эзэмшиж буй зэрэглэлүүдийн дагуу үндсэн цалингийн 3 дугаар түвшингийн сүлжээг ур чадвар хадгалсан цагт ногдуулж олгоно.

#### Зургаа. Хариуцлага

6.1. Ур чадвар хадгалагч нь нислэгийн хөдөлгөөний удирдлага, үйлчилгээг үзүүлж байх хугацаанд Нислэгийн удирдагчийн нэгэн адил Иргэний Нисэхийн тухай Монгол Улсын хууль болон холбогдох багц дүрэм, журам, заавруудын дагуу хариуцлага хүлээнэ.

М. Сүхбаатар  
Ур чадвар хадгалуу

ХЯНАЛТАН ХУУЛЬ  
2018-08-28  
АДЧЕК